



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: ШУТИС-ийн Механик, тээврийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Менежмент хөтөлбөрийн тээврийн менежмент

Индекс: D041302

Шинжээчийн баг:

Ахлагч: Р.Чанцалдулам

Гишүүд: Б.Батдэлгэр

Б.Буманцэцэг

2021.12.15

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Товчилсон үгийн тайлбар

| | |
|----------------------------|---|
| БШУЯ, БМИУЗ STEEP | Боловсрол, Шинжлэх Ухааны Яам Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл Social, Technological, Economic, Environmental, Political analysis - Нийгэм, Технологи, Эдийн засаг, Хүрээлэн буй орчин, Улс төрийн үр нөлөөг тооцох чиг хандлагын шинжилгээний арга. |
| UNIMIS Lib4U PEOs | Удирдлагын Мэдээллийн Систем Цахим номын сангийн платформ Program Educational Objectives Хөтөлбөрийн боловсролын зорилтууд |
| PLOs | Program Learning Outcomes- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд |
| CLOs | Course Learning Outcomes Хичээлийн суралцахуйн үр дүнгүүд |
| ҮДСБ ЭЕШ ЭША PDCA | Үр Дүнд Суурилсан Боловсрол Элсэлтийн Ерөнхий Шалгалт Эрдэм Шинжилгээний Ажил Plan, Do, Check, Act Төлөвлө, Гүйцэтгэ, Шалга, Сайжруул |
| ЕБС ЭШБх МехТС | Ерөнхий Боловсролын Сургууль Эрдэм Шинжилгээний Бага Хурал Механик, тээврийн сургууль |

II. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

| | | |
|--------------------------------|--|---|
| Сургуулийн нэр | ШУТИС, Механик, Тээврийн сургууль | |
| Хөтөлбөрийн нэр, индекс | Менежмент / Тээврийн/, D041302 | |
| Шинжээчид | Ахлагч: Р.Чанцалдулам_ Хөдөө аж ахуйн Их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, доктор Гишүүн: Б.Буманцэцэг Зам,тээврийн хөгжлийн яамны Хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн Тээврийн нэгдсэн удирдлага зохицуулалтын ахлах мэргэжилтэн Н.Батдэлгэр Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн багш, доктор | |
| Зохицуулагч | Б. Оюунцэцэг | |
| Төлөвлөгөө | Өдөр | Хийгдсэн байх ажлууд |
| | 2021.11.18 | Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх |
| | 2021.11.29 | Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх |
| | 2021.12.05 | Сургуулийн бэлэн байдлыг нягтлах |
| | 2021.12.06, 07 | Шинжээчид сургууль дээр ажиллах |
| | 2022.01.05 | Шинжээчид магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх |
| | 2022.01.10 | Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох |
| | | Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах |
| Шалгуур шаардлага | БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн 001 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав. | |

III. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Тус хөтөлбөрийн баг нь 2001 онд ШУТИС-ийн дэргэд Механик, инженерийн сургуулийн бүтцэд суурь боловсролын тэнхим нэртэйгээр анх үүсгэн байгуулагдаж “тээврийн менежмент”, “олон улсын тээврийн менежмент” мэргэжлүүдээр мэргэжилтэн бэлтгэж ирсэн.

Түүнчлэн 2003 онд Тээврийн логистик, менежмент, 2010 оноос Логистик, менежментийн профессорын баг нэгтэйгээр ажиллаж байгаад 2014 оны бүтцийн өөрчлөлтөөр Тээврийн салбарт харьяалагдсан түүхтэй. Монгол улсын хэмжээнд тээврийн салбарт орчин үеийн тээврийн менежментийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар шаардсан мэргэжилтний эрэлт хэрэгцээ ихтэй гэдгийг ажил олгогч, төгсөгчидтэй хийсэн уулзалтаас харагдаж байна. 3 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчдийн баг хөтөлбөрт үнэлгээ хийсэн бөгөөд дараах давуу талуудыг онцолж байна. Үүнд:

- ✓ Хөтөлбөрийг 2014 онд БСШУСЯ- ны А/174 тоот бакалаврын хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу боловсруулсан тасралтгүй сайжруулан хэрэгжүүлдэг.
- ✓ 2001 оноос хойш 20 гаруй жил сургалт явуулж ирсэн туршлагатай, багшлах бүрэлдэхүүний чадамж өндөр нийт багш нарын 87.5 хувь нь эрдмийн зэрэгтэй.
- ✓ Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, оролцогч талуудын санал хүсэлтийг тусгах, гадаадын ижил төстэй их, дээд сургуулиудын туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр туршлагатай, хичээн ажилладаг.
- ✓ Удирдлагын мэдээллийн системээ сайн хөгжүүлж, үр дүнтэй ашиглаж, богино хугацаанд цахим сургалтын платформыг хөгжүүлсэн нь зайн сургалтыг явуулах нөхцөл, үндсэн суурь бий болсон байна.
- ✓ Хичээл нэг бүрийг судалж дууссаны дараа дүн гарахаас өмнө суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг онлайнгаар авдаг болсон нь хөтөлбөрийг цаашид сайжруулах, удирдан зохион байгуулахад тус дөхөм болж байна.
- ✓ Суралцагчийн танилцах болон мэргэжлийн дадлагыг үндэсний болон олон улсын тээвэр зуучийн байгууллагатай хамтран үр дүнтэй удирдан явуулдаг.
- ✓ 2004 оноос эхлэн нийт 35 удаагийн төгсөлтөөр 445 мэргэжилтэн бэлтгэн гаргасан төгсөгчдийн 90 гаруй хувь нь мэргэжлийн байгууллагад ажилладаг. Сүүлийн жилүүдэд төгсөгчийн мэргэжлийн чиглэлээр ажил эрхлэлтийн хувь 83% (2019) байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, чиг хандлагыг тодорхойлохдоо STEEP шинжилгээ хийсэн тухай өөрийн үнэлгээний тайланд бичсэн ч нотлох баримт байхгүй.
- ✓ Харин хөтөлбөрийг шинэчлэн сайжруулахдаа оролцогч талууд болох багш, төгсөгч, ажил олгогчоос санал асуулгын болон хэлэлцүүлгийн аргаар судалгаа авч, тэдний санал дүгнэлтэд үндэслэн 2016 онд хөтөлбөрийг сайжруулсан байна.
- ✓ Хөтөлбөрийн оролцогч талуудаас судалгаа авч түүнд дүн шинжилгээ хийдэг. Ажил олгогчоос жилд нэг удаа, төгсөгч, оюутнуудаас жил, улирал бүр судалгаа авч ажилладаг нь судалгааны тайлан, удирлагын мэдээллийн систем, асуулгын анкет зэргээр баталгаажсан.

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах тогтолцоог бүрдүүлж, чанарын соёлыг бий болгох;
- ✓ Хөтөлбөрийн зах зээлийн тандан судалгаа болон эрэлт хэрэгцээг тодорхойлох шинжилгээг зохион байгуулалттай, ажил хэрэгч, үр дүнд чиглэж хийж хэвших;
- ✓ Гадаад дотоодын их сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан шинжилгээний үр дүнг хөтөлбөрт тусгадаг байх;

- Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийн төгсөгчийн загварыг гаргахдаа үр дүнд суурилсан үзэл баримтлалыг баримталж, менежментийн ерөнхий мэдлэг, чадвартай тээврийн үйл ажиллагааг сайн мэддэг, түүнийг удирдан зохион байгуулах бүтээлч хандлага, хариуцлагатай, шинийг санаачлагч, мэргэжлийн болон харилцааны ур чадвартай байхаар тодорхойлсон байна.
- ✓ Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо ШУТИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, МехТС-ийн эрхэм зорилготой уялдуулан боловсруулсан.
- ✓ Хөтөлбөр нь 2014 (123), 2016 (125) онуудад шинэчилж сайжруулж ирсэн байна.
- ✓ Хөтөлбөрийн зорилго зорилтыг тодорхойлохдоо хөтөлбөрийн үндсэн мэргэжлийн багш нарыг оролцуулдаг.
- ✓ Хөтөлбөрийг төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан нийтлэг шаардлага, холбогдох дүрэм журамд нийцүүлэн боловсруулан хэрэгжүүлж байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо тухайн хөтөлбөрт ордог бусад мэргэжлийн багш, ажил олгогчийн төлөөллийг оролцуулдаг байх, тэдний санал бодлыг сонсдог байх хэрэгтэй. Учир нь хөтөлбөрийн боловсролын зорилго нь тухайн хөтөлбөрөөр төгсөгч нь ажлын байранд гараад 4-5 жилийн дараах хэрэглэж чадах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байхаар тодорхойлох шаардлагатай.

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан/

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ 2014 онд батлагдсан хөтөлбөрийн баримт бичигтэй. 2016 онд хөтөлбөрийг шинэчлэхдээ сургалтын төлөвлөгөөнд зөвхөн өөрчлөлтийг оруулан баталсан байна.
- ✓ Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлд тээврийн менежмент хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд нэмэлт өөрчлөлт оруулах, ур чадварыг дахин тодорхойлох, түүнтэй холбогдуулан сургалтын төлөвлөгөөг өөрчлөх талаар ярилцсан нь байгаа нь хөтөлбөрийг тасралтгүй сайжруулахад анхаарч ажиллаж байгааг харууллаа.
- ✓ Сургалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу 125 кредит цагийн хичээлүүдийг судалж 4 жил суралцаж төгсөхөөр дараах байдлаар төлөвлөсөн байна. Тухайлбал, сургалтын төлөвлөгөөний нийт судлах багц цагт мэргэжлийн суурь болон дадлагын хичээлийн судлах цагийг нэмэгдүүлсэн байна.

| Сургалтын төлөвлөгөөний бүтэц | 2014 он | | 2016 он | |
|-------------------------------|---------|------------|---------|------------|
| | Кредит | Эзлэх хувь | Кредит | Эзлэх хувь |
| Ерөнхий суурь | 36 | 29.2% | 36 | 28.8% |
| Мэргэжлийн суурь | 33 | 26.4% | 36 | 28.8% |
| Мэргэжлийн | 44 | 35.7% | 42 | 33.6% |
| Дадлага | 5 | 4.1% | 6 | 4.8% |
| Төгсөлтийн шалгалт/диплом | 5 | 4.1% | 5 | 4.1% |
| | 123 | 100 | 125 | 100 |

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн үндсэн баримт бичгийг сайжруулан шинэчлэх.
- Үр дүнд суурилсан боловсролын онол арга зүйн дагуу төгсөгчийн загвар(Graduate attributes), хөтөлбөрийн боловсролын зорилтууд(PEOs), хөтөлбөрийн суралцахуйн үр

дүнгүүд(PEOs) нь өөр хоорондоо уялдаж байгаа хөтөлбөрийн хүрэх үр дүн, хичээлийн хүрэх үр дүнтэй хосолсон матрицыг шинэчлэн боловсруулах;

Шаардлага:

- ✓ Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгийг сайжруулахдаа дараах зүйлийг анхаарч ажиллах: Үүнд:
 - Хөтөлбөрийн боловсролын үр дүнг (PEOs)-ийг суралцахуйн үр дүнтэй нийцүүлэх;
 - Хөтөлбөрийн зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнг тодорхойлохдоо багш, ажил олгогч, төгсөгч зэрэг оролцогч талуудын оролцоог хангаж, хэлэлцүүлэн гаргадаг байх;
 - Хөтөлбөрийн эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох холбогдох нотлох баримтуудыг архивлан хөтөлж байх. Үүнд: оролцогч талуудын сэтгэл ханамжийн тайлан, судалгааны үр дүнг танилцуулсан уулзалт, хийсэн хэлэлцүүлэг, асуудлыг шийдвэрлэсэн байдал, хөтөлбөрийн эрэлт хэрэгцээний тандан судалгаа, STEEP, ROEMS зэрэг шинжилгээг хийсэн ажлын хэсгийн тушаал, тайлан, гаргасан дүнг хөтөлбөрийн төлөвлөлтөд оруулсан тухай тушаал, албан тоот гэх мэт.
 - Элсэгч, суралцагч, төгсөгчидтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөлтийн баримтуудыг боловсруулан мөрддөг байх;
 - Багш бүрийн хичээлийн иж бүрдлийг лекцийн материалаас гадна дадлага хичээл болон түүнийг удирдан явуулах сургалтын арга зүйн удирдамж, лабораторийн заавар, явцын болон улирлын шалгалтын материал, бие даалтын удирдамж, бусад хэрэглэгдэхүүний талын мэдээллийг бүрэн оруулах, эдгээр бичиг баримтын төлөвлөлтийг үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу боловсруулах шаардлагатай.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

1-р шалгуурын талаарх эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, суралцахуйн үр дүнг 2014, 2016 онуудад тус тус шинэчлэл хийсэн нь нотлох баримтаар баталгаажсан.
- ✓ Удирдлагын мэдээллийн системд хичээл сонголт хийх, хичээлийн үнэлгээ, суралцагч, багшийн мэдээлэл, түүнтэй холбоотой холбогдох тайланг гаргах боломжтой.
- ✓ Цахим сургалтын платформыг ашиглахаас гадна Microsoft teams ашиглаж цахим сургалтыг явуулдаг.
- ✓ Сургалтын төлөвлөгөөний дагуу танилцах дадлага, мэргэжлийн дадлага I,II гэж хийдэг бөгөөд тээврийн үйлчилгээний чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллага болох Автотээвэр, төмөр зам, зорчигч тээврийн компанитай хамтран ажилладаг.Түүнчлэн

ОХУ-ын Эрхүү хотын байгалийн улсын их сургуулийн танхим, Эрээн хотын зарим тээвэр зуучийн компанитай хамтран олон улсын тээвэр зуучийн байгууллагын үйл ажиллагаатай танилцаж мэргэжлийн дадлага хийдэг байна.

- ✓ Тус хөтөлбөрөөр суралцагчийн ачааллыг харахад 1-р ангид 16.6, 2-р ангид 17.2, 3-р ангидаа 17.17, 4-р ангидаа 14.0 кредит цагийн ачаалалтай байна.

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн үр дүн хоорондын хамаарлыг сайжруулах;
- ✓ Хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг хийхдээ хөтөлбөрийн хүрэх үр дүн, төгсөгчийн загварт шинэчлэлт хийсний дараа сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт хийдэг байх;

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан/

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Үр дүнд суурилсан үзэл баримтлал CDIO орчин үеийн сургалтын арга зүйг хэрэглэдэг нь нотлох баримтаар баталгаажсан.
- ✓ Хөтөлбөрийн хичээлүүдийн сургалтын заах арга зүй нь мэдлэг бүтээх, хэрэглэж сургахад чиглэсэн асуудалд суурилсан сургалт, туршилтад суурилсан, хэлэлцүүлгийн арга, тонгоруу анги зэрэг аргуудыг хэрэглэдэг.
- ✓ Сургалтын арга зүйг хэрэглэсэн талаарх мэдээллийг мэргэжлийн багшийн хичээлийн иж бүрдэл, хичээл заасан баримтууд болон оюутнуудтай уулзсан уулзалтаас асууж нотолгоог баталгаажуулсан.
- ✓ Хөтөлбөрийн багш нарын хувьд UNIMIS системээс гадна ZOOM, Microsoft teams зэрэг программ хангамжийн тусламжтайгаар хичээлийг үр дүнтэй явуулах цахим сургалтын арга зүйд сайн суралцсан.
- ✓ Цахим сургалтын үед хэрэглэх лекцийн болон дадлагын хичээлийн видео бичлэг, даалгавар хийх зааврыг өгч ажилладаг.

Зөвлөмж:

- ✓ Багш бүр хичээлийн заах арга зүйд дүгнэлт хийж, сайжруулж ажилладаг байх;
- ✓ Цаашид хөтөлбөрийн онцлогоос хамааран ямар сургалтын аргууд тухайн хөтөлбөрт тохирох, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх арга зүй, удирдамж, заавар гаргаж ажиллах.

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан/

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ ШУТИС-ийн захирлын 2014 оны А/54 тоот тушаалаар батлагдсан бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмыг баримталдаг.
- ✓ Оюутны мэдлэгийг үнэлэхдээ тухайн хичээлийн хувьд багш 70 оноог, хөндлөнгийн 30 онооны шалгалтыг авч тус тус үнэлдэг. Хичээлийн шалгалтын тестийг өөрчилж СТО010 маягт бөглөж хөтөлбөр хариуцсан профессор хянадаг байна.

- ✓ Багшийн хичээлийн онцлогоос хамааран ирц, идэвх 10-20 оноо, явцын шалгалт, сорил 20 оноо, бие даалт 30-40 хүртэлх оноогоор багшийн 70 оноог дүгнэдэг. Оюутнуудад олгох мэдлэг, чадвараас гадна олгох хандлагыг дүгнэх рубрикийн үнэлгээний аргыг хэрэглэдэг.
- ✓ Удирдлага мэдээллийн системд хичээл бүрийн дүнгийн тархалтыг тооцож дүн шинжилгээ хийдэг.
- ✓ Хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн голч дүн нь 2.89 байна. Суралцагчдын сурлагын амжилт нь өмнөх жилүүдээс өссөн үзүүлэлттэй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хичээл нэг бүрийн суралцахуйн үр дүнг (CLOs) хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүйн зөвлөмж бүхий гарын авлага боловсруулж, хөтөлбөрийн багш нарт хүртээл болгон ажиллах;
- Багш нарыг сурган, заах арга зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, тасралтгүй хөгжүүлэх багшийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг гаргаж, хэрэгжүүлэх.
- Хичээлийн өөрийн үнэлгээний тайланг дүгнэж хэвших.

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан/

2-р шалгуурын талаарх эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Тээвэр зуучийн компаниудын дэмжлэгтэйгээр мэргэжлийн лекц, семинарын анги танхимын тохижилт, шинэчлэлтийг сайжруулж оюутнуудыг тав тухтай орчинд суралцах, мэргэшүүлэх хичээлүүдийн лабораторийг материаллаг баазаар хангасан байна.
- ✓ Хөтөлбөрт хамрагдаж буй оюутнууд эрүүл мэндийн анхан шатны тусламж, шаардлагатай тарилга, боолт, физик эмчилгээ, бариа заслын эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах боломжийг хангасан байна.
- ✓ G-mobile шилэн кабелийн сүлжээг ашиглан багш оюутны хэрэгцээнд хүртээмжтэй байхаар интернетээр хангах үйлчилгээг үзүүлж байна.

Онцлог/Туршлага:

- ✓ Автомашины засварын болон автомашины бүтэц, хийцийн лабораторитой.
- ✓ Хөдөө орон нутгаас ирсэн дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан оюутнуудыг бүрэн хамруулдаг. Дотуур байрны хүрэлцээ сайн.

Зөвлөмж:

- ✓ Төмөр зам, агаар, усан тээврийн лабораторийг бий болгох;
- ✓ Зарим анги танхим, дотуур байрны дулаалга, халаалтын асуудлыг сайжруулах;
- ✓ Бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамжийг сайжруулах;

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан/**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ МехТС-ийн 122, 123, 407 тоот ангиудад хичээллэх оюутан нь компьютер ашиглах бүрэн боломжтой. Нийт компьютерийн тоо 50 ширхэг. 1 суудалд 2 оюутан оногдохоор хангагдсан байна. Лекц, семинарын анги танхим бүрд проектор, TV суурилуулсан байна.
- ✓ ЗТХЯ, Үндэсний хөгжлийн газар, тээвэр зуучийн компаниудад мэргэжлийн болон танилцах дадлага хийсэн тухай албан бичиг, санамж бичиг, гэрээтэй.
- ✓ Оюутан нь өөрийн код болон нууц үгийг ашиглан оюутны вэб-д нэвтрэн орж лекц, семинар болон дадлагын даалгавар тайланг цахим хэлбэрээр үзэх боломжтой.
- ✓ 17 төрлийн хичээлийн агуулгад мэргэжлийн 5 программ хангамжийг хэрэглэдэг.
- ✓ Цахимаар хичээл заах анги, танхимыг тусгайлан тохижуулж мэргэжлийн камер, самбар, техник хэрэгслээр бүрэн хангаж өгсөн байна.

Онцлог/Туршлага:

- ✓ ОХУ-ын Байгалийн улсын их сургуультай хамтран ажиллах гэрээтэй. Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Монгол улсын далайн захиргаатай хамтарч ажиллах хамтын ажиллагааны санамж бичигтэй.
- ✓ Ковид-19 цар тахлаас өмнө Монгол улсын Өмнөд хилийн гаалийн байгууллага, Төмөр замын Шилжүүлэн ачих анги, Автотээврийн үндэсний төвийн Замын-үүд салбар болон БНХАУ-ын Эрээн хотын гаалийн цогцолбор байгууллага, тээвэр зуучийн байгууллагуудтай танилцах мэргэжлийн дадлагын удирдамж боловсруулж оюутнуудыг мэргэжлийн дадлага хийх боломж нөхцлөөр хангасан байна.

Зөвлөмж:

- ✓ Мэргэжлийн дадлага хийх хугацаа, кредит цагийг нэмэгдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх;
- ✓ дадлага хийж буй оюутнуудын аюулгүй байдлыг хангахад анхаарч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгч байх;
- ✓ сургалтын хэрэглэгдэхүүн, хүртээмж, ашиглалтад багш, оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч, түүний дагуу төлөвлөгөө гаргаж арга хэмжээ авах;
- ✓ Мэргэжлийн чиглэлээрх албан ёсны лицензтэй программын тоог нэмэгдүүлэх;

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан/**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Must.lib4u.net цахим номын сангийн сайтаар орж ном хайх, ном захиалах, онлайнаар ном, гарын авлага, эрдэм шинжилгээ, дипломын ажил үзэх боломжтой.
- ✓ Номын сангийн фондод тээврийн менежмент мэргэжлийн 2405 ширхэг сурах бичиг байна.
- ✓ Цахим номын санлуу орж ямар ном аль номын санд хичнээн ширхэг байгааг мэдэх боломжтой.
- ✓ 2019 оноос хойш тээврийн менежмент мэргэжлийн номын баяжилт хийгдээгүй. Сургуулийн төсөвт хөрөнгө мөнгө нь ороогүй. 2022 оны төсөвт оруулахаар ажиллаж байна.

Онцлог/Туршлага:

- ✓ Гадаад хэл дээр тээвэр, логистиктой холбоотой номтой.
- ✓ Салбарын зарим багш нар өөрсдийн гарын авлага, ном сурах бичгийг гаргасан байна.

Зөвлөмж:

- ✓ Өөрийн сургуулийн багш нарын гаргасан ном, сурах бичгийг цахим хэлбэрт оруулж оюутнуудыг гэрээсээ цахимаар судлах боломж олгох.
- ✓ Үндсэн сурах бичиг, ном, гарын авлагын талаар оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч түүний дагуу арга хэмжээ авч ажиллах.
- ✓ Тээврийн менежмент хөтөлбөрөөр суралцагчдад зориулсан бие даалтын гарын авлага, материал, удирдамж боловсруулж гаргах.

Шаардлага:

- ✓ Номын сангийн фондыг “тээврийн менежмент” хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийн үндсэн сурах бичгээр баяжуулах;
- ✓ Оюутнуудад зориулж бие даалтын өрөөг гаргаж бие даан болон багаар ажиллах боломжийг бүрдүүлэх
- ✓ Менежмент хөтөлбөрийн багш нарт сурах бичиг, гарын авлага хэвлүүлэхэд туслах, санхүү мөнгийг байгууллагын төсөвт тусгаж байх

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан****Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Тээврийн менежментийн мэргэжлийн менежментийн баг нь салбар сургуулийн болон их сургуулийн хөтөлбөрийн хороодтой үйл ажиллагаагаа журмын дагуу уялдуулан ажилладаг.
- ✓ Хөтөлбөрийн хороодын шат бүрд хөтөлбөрийн оролцогч талуудын санал, зөвлөмжийг тусгахад анхаардаг болох нь хөтөлбөрийн хороодын тэмдэглэлээс харагдсан.
- ✓ Их сургуулийн болон салбар сургуулийн Сургалтын бүхий л үйл ажиллагаанд Unimis, Microsoft Teams, Unilms програмуудыг ашиглаж байна.

Онцлог/Туршлага:

- ✓ [ШУТИС | Оюутны вэб \(must.edu.mn\)](https://must.edu.mn) Сайтаар улирал бүр оюутнуудаас санал асуулга авдаг.
- ✓ mes.edu.mn/cc сайтаар багш, ажилчдын саналыг хүлээн авдаг. Багшийн вэб хуудсанд оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг танилцуулдаг.

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөг гаргах хэрэгтэй.
- ✓ Хөтөлбөрийг сайжруулахад оролцогч талуудын (Багш, оюутан) оролцоог хангаж ажиллах;
- ✓ Багш, ажилчид, оюутнуудаас санал асуулга авсны дараа түүний мөрөөр арга хэмжээ авч шийдвэрлэдэг байх;
- ✓ Тээврийн менежмент мэргэжлээр төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг өргөжүүлж, энэхүү мэргэжлээр суралцаж буй оюутан залуустай төгсөгч-оюутнуудын хамтарсан уулзалт зохион байгуулж туршлага хуваалцаж байх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гаргасан эрэлттэй ажил, мэргэжлийн жагсаалтыг үндэслэн “JICA” олон улсын хамтын ажиллагааны байгууллагын төсөл хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн тандалт, судалгааг гаргасан байна.
- ✓ Сургалтын бодлого зохицуулалтын албанаас профессор, багш ажилтнуудын ажил үйлчилгээний талаар оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг цахимаар авсан байна.
- ✓ Тээвэр-логистикийн болон тээвэр зуучийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээтэй.
- ✓ Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын судалгаа, дүрэм журамтай.

Онцлог/Туршлага:

- ✓ Тус хөтөлбөрийн багш нар 2008 оноос эхлэн Eastern Asia Society for transportation studies EASTS буюу Зүүн Өмнөд Азийн Тээвэр судлалын нийгэмлэгийн гишүүн болж гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн.
- ✓ 2011 оноос эхлэн ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн улсын их сургуулийн “Бизнесийн удирдлагын тэнхим”-тэй хамтран ажиллахаар албан ёсны хамтын ажиллагааны гэрээг байгуулан өнөөг хүртэл амжилттай хамтран ажиллаж байна.

Зөвлөмж:

- ✓ Тээвэр-логистикийн байгууллагууд болон тээвэр зуучийн байгууллагуудтай хамтран ажиллах урт, богино хугацааны төлөвлөгөө гаргаж ажиллах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- ✓ Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- ✓ Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа

Онцлог/Туршлага:

- ✓ Дотоод болон гадаад аудитыг жил бүр хийлгэж төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж байна.
- ✓ Оюутанд үзүүлэх үйлчилгээний зардлыг сургуулийн жил бүрийн төсөвт тусгасан байна.
- ✓ ШУТИС Ректорын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А-223-р тушаалаар баталсан “ШУТИС-ийн оюутнуудад кредитийн урамшуулал олгох журам” хэрэгждэг.

Зөвлөмж:

- ✓ Багш нарын гадаад дотоод эрдэм шинжилгээний хуралд оролцоход дэмжлэг өгч урамшуулж байх;
- ✓ Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайланг гаргадаг байх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Ковид-19 цар тахал гарахаас өмнө ажлын байрны нээлттэй өдөрлөг “JOB Fair” арга хэмжээг зохион байгуулж ирсэн.
- ✓ Тээврийн менежмент мэргэжлийн хөтөлбөрийн идэвхжүүлэлтийг дараах хэлбэрүүдээр хийдэг.
 - боловсролын үзэсгэлэн яармагт оролцох,
 - ЕБС-ийн сурагчдад мэдээлэл, мэргэжил сонголтод туслах зорилгоор томилолтоор ажиллах,
 - ШУТИС-Бидний бахархал, өдөрлөгт оролцох, МехТМ-ийн “Бид оюутан боллоо” өдөрлөгт оролцох,
 - МехТС-ийн JOB Fair өдөрлөгт оролцох

Онцлог/Туршлага:

- ✓ Жил бүр ажлын байрны нээлттэй өдөрлөг зохион байгуулдаг.

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулж түүний дагуу үе шаттай ажлуудыг зохион байгуулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийн үйл ажиллагаанд ШУТИС-ийн хэмжээнд гарч буй бодлогын шийдвэр, өөрчлөлтүүдийг ШУТИС-ийн веб хуудсаар, МехТС-ийн захирлын зөвлөл, сургалтын алба, зөвлөх багш нараар дамжуулан оюутанд цаг тухайд нь мэдээллийг шуурхай

хүргэдэг. Сургалтын бүхий л үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг сургууль доторх мэдээллийн самбар, зарын дэлгэц болон сургуулийн веб хуудсаар дамжуулан авах боломжтой байна.

- ✓ Сургуулийн динамик вэб сайтаас багш нарын талаарх мэдээлэл, судалгааны чиглэл, цаг үеийн мэдээ мэдээллүүдийг нээлттэй байдлаар авч болдог.
- ✓ Албан бусаар хөтөлбөрийн суралцагч, төгсөгчдийн Facebook групп, Instagram, Teams-ийн бүлэг группүүдээр дамжуулан хөтөлбөрийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлууд хийгддэг.

Онцлог/Туршлага:

- ✓ Сургуулийн вэб сайтны “Элсэгчдэд зориулсан мэдээлэл” цэсэнд <http://mes.edu.mn/mn/?page=041302> тухайн хөтөлбөрөөр суралцахыг хүсэгчдэд зориулсан мэргэжил сурталчилсан хэсэгтэй. Энэхүү хэсэгт мэргэжлээ сонгож чадахгүй байгаа эсвэл эргэлзэж байгаа элсэгчдэд зориулан тухайн мэргэжлийн ач холбогдол, давуу тал, суралцах орчин нөхцөл, төгсөөд ажиллах ажлын байрны талаар сурталчилж тайлбарласан видео контент, мэдээллийг байршуулсан.

Зөвлөмж:

- ✓ Төгсөлтийн дараах бодлогыг сайжруулж салбарын ажил олгогч нартай нягт хамтран ажиллах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн тушаалууд, элсэлтийн журам, өөрийн үнэлгээний тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэлт, бүртгэл, сургалтын үйл ажиллагаатай холбоотой журам тодорхой;
- Байнгын тогтмол элсэгчтэй;
- Багш оюутны харьцаа бага, оюутан бүртэй ажиллах боломжтой (ӨYT-гийн хуудас 96: Мэргэжлийн багшид 10 хүртэл оюутан ногддог);

Анхаарах асуудал:

- Олон оюутан шинээр элсдэг хэдий ч цөөн оюутан төгсөж байгаа шалтгаанд анхаарах;
- Оюутнуудын шилжилтийн шалтгааныг тодорхойлох судалгааг хийх;

Шалгуурыг хангасан байдал: /Бүрэн хангасан/

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ МехТС-ийн захирлын тушаал
- ✓ Оюутны зөвлөлийн тайлан
- ✓ Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааны тайлан (Багшийн хувийн сувгаар авсан судалгаа)

Онцлог зүйл/Туршлага:

- ✓ Зөвлөн туслах үйл ажиллагаа тогтмолжсон. Тэр дундаа зөвлөх багш нар, дотуур байрны зөвлөл, оюутны холбооны үйл ажиллагаа тогтмолжсон.
- ✓ Оюутнуудыг нэгдүгээр курсэд элсэн орсон үеэс ангид хуваарилж зөвлөх багш томилдог (МехТС-ийн захирлын 2021.02.08 ны өдийн А/12 дугаар тушаал)
- ✓ Төгсөгчдийн ажил эрхлэлт, бүртгэл судалгааг жил бүр явуулдаг.
- ✓ Дотуур байранд сургуулийн эмч байрладаг.
- ✓ Хөтөлбөрийн нийт багш нар тус мэргэжлийн онцлог, давуу тал, цаашдын ажлын байрны хэрэгцээ шаардлага, олдоц зэрэг өргөн хүрээнд ярилцлага. Семинаруудыг жил бүр зохион байгуулдаг → (Хэвлэсэн powerpoint танилцуулга)

Анхаарах асуудал:

- ✓ Оюутны сэтгэл ханамжийн судалгааны зорилго тодорхойгүй. (Зөвхөн атестачлалын үеэр хувь хүн болгонд танилцуулдаг (ӨҮТ хуудас 101)), багш нар оюутны сэтгэл ханамжийн судалгаатай цаг тухайн бүрт танилцдаггүй.
- ✓ Мэргэжлийн үнэ цэн, ач холбогдлын талаар оюутнуудад өмнө нь өгч байснаа илүү хэмжээний, хангалттай хэмжээний мэдээллээр хангах чиглэлээр өмнөхөөс илүү идэвхитэй ажиллах (Төгсөгчидтэй хийсэн уулзалтын үр дүнгээс: төгсөгчид ажлын байранд гарсны дараа өөрийн мэргэжлийн үнэ цэнийг ойлгодог. Оюутан байхдаа илүү их хэмжээний чиглүүлгийг авах хүсэлтэйгээ илэрхийлж байсан)
- ✓ Төгсөгчдийг сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний туршлагаас судлах (Төгсөгчидтэй хийсэн ярилцлагын үр дүн: үйлдвэрлэлийн дадлага хичээлийн хүрээнд)
- ✓ Суралцаж байх хугацаанд тухайн мэргэжлийн онцлог шинж чанар, ажлын байрны талаар илүү их мэдээлэл өгөх, оюутнуудыг чиглүүлэхэд анхаарах. (Төгсөгчидтэй хийсэн ярилцлага),

Зөвлөмж:

- Багш нар өөрийн заасан хичээлийн сэтгэл ханамжийн судалгаатай танилцдаг байх, тухайн судалгааны үр дүнг хөтөлбөрийг хэрэгжүүлж буй баг хэлэлцдэг байх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Оюутны зөвлөлийн тайлан
- ✓ Оюутнуудын уралдаан тэмцээнд оролцсон талаарх тэмдэглэл
- ✓ ШУТИС-ийн оюутнуудад кредитийн урамшуулал олгох журам

Онцлог зүйл/Туршлага:

- ✓ Оюутны зөвлөл нь тайлан гаргадаг.
- ✓ Жил бүр тодорхой хэмжээгээр оюутнуудад мөнгөн урамшуулал олгодог (ӨҮТ хуудас 157, хавсралт 13)

Анхаарах асуудал:

- ✓ Тэтгэлэгт хөтөлбөрийн тодорхойлолт тодорхойгүй (Кредитийн урамшуулал болон тэтгэлэгт хөтөлбөр) байгаад анхаарах;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Төгсөлтийн бичиг баримт
- ✓ Төгсөлтийн тушаал

Онцлог зүйл/Туршлага:

- ✓ Бүх төгсөгч төгсөлтийн ажил бичиж хамгаалдаг

Анхаарах асуудал:

- ✓ Хэрвээ оюутнууд төгсөлтийн ажил бичихгүй тохиолдолд, төгсөлтийн шалгалт бичих шаардлага үүснэ. Энэ тохиолдолд төгсөлтийн ажлын 5 кредит цагийн багтаамжийг хэрхэн судлах вэ? гэдэг нь тодорхойгүй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Профессор багшийн багц материал (5 багшийн материал)
- ✓ Профессор багш нарын гүйцэтгэсэн кредит, Тээврийн салбар
- ✓ Профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам

Онцлог зүйл/Туршлага:

- ✓ Докторын зэрэгтэй багш нарын хувийн жин өндөр 87.5%
- ✓ Профессор багш нарын цагийн ачаалал хэт их биш

Анхаарах асуудал:

- ✓ Нийт багш нарын 87.5% нь докторын зэрэгтэй хэдий ч зөвхөн нэг л хөтөлбөр хариуцсан дэд профессор ажилладаг (Багш нартай хийсэн ярилцлага: ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам 4.9.6)
- ✓ Цаашид хөтөлбөр хариуцсан дэд профессорын ажиллах хугацаа, ажлын ачааллыг зохицуулах шаардлагатай
- ✓ Дэд профессорын цолтой доктор багш ахлах багшийн зэрэглэлд ажилладаг (Багш нартай хийсэн ярилцлага)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Багшийн хөгжлийн хөтөлбөр
- ✓ Багш нарын хэвлэж нийтлүүлсэн бүтээлүүд

Онцлог зүйл/Туршлага:

- ✓ Хөтөлбөрийн багш нар сургалт семинарт тогтмол хамрагддаг.

Анхаарах асуудал:

- ✓ Тус хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэхийн зөвхөн нэг багш /хөтөлбөр хариуцсан дэд профессор/ -д ачаалал өгөх бус, багаар ажиллах шаардлагатай.
- ✓ Дэд профессорын цолтой хэдий ч ахлах багшийн зэрэглэлд ажиллах, хөтөлбөр хариуцахгүй л бол ахлах багшийн зэрэглэлд ажиллах нь багш нарын карьер менежмент, цаашид албан тушаал өсөж дэвших хүсэл эрмэлзэл буурах, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх эрмэлзэл буурах эрсдэлтэйг анхаарах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Багш нарын хэвлэж, нийтлүүлсэн бүтээлүүд
- ✓ Эрдэм шинжилгээний ажлын, Б цагийн гүйцэтгэл (илүү хийж байна)

Онцлог зүйл/Туршлага:

- ✓ Профессор багш нар эрдэм шинжилгээ, судалгааны ажил тогтмол гүйцэтгэдэг.

- ✓ JCR-IF бүхий сэтгүүлд багш өгүүллээ хэвлүүлсэн.

Анхаарах асуудал:

- ✓ Эрдэм шинжилгээний мэдээллийн сан ашиглалтын өнөөгийн байдал ямар түвшинд байгаа, бүтээлээ олон улсын нэр хүндтэй сэтгүүлд хүлээн зөвшөөрүүлэх ажлыг эрхлэлийг хэрхэн гүйцэтгэж буй, өгүүллийн гадаад дотоодод эшлэгдсэн байдлын нотолгоо, тандалт судалгааг хийж сургуулийн ЭШ-ний тайланд тусгаж байх.
- ✓ Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн үнэлгээ буурч байгааг анхаарах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Цахим хуудсанд өөрийн үнэлгээг хийдэг (professor.must.edu.mn), шинжээчид сургууль дээр ажиллах үед тус систем ажиллахгүй байв.
- ✓ Жил бүр Б цагийн нормыг гүйцэтгэдэг.

Онцлог зүйл/Туршлага:

- ✓ Багш нарын өөрийн үнэлгээний тайлан цахимжсан.
- ✓ Хичээл заасан багшийг оюутнууд үнэлдэг (гэхдээ тухайн үнэлгээ нь багш нарт мэдээлэгддэггүй). Сэтгэл ханамжийн судалгааны хэсэг professor.must.edu.mn платформд байгаа хэдий ч тухайн систем ажилладаггүй.

Анхаарах асуудал:

- ✓ Оюутан бүр багш хичээл заасан багшаа үнэлдэг хэдий ч тухайн үнэлгээг дараа, дараагийн хичээл заахад ашиглах талаар анхаарах хэрэгтэй. (Багш нартай хийсэн ярилцлага: Багш нар сэтгэл ханамжийн судалгааны үр дүнтэйгээ танилцаагүй байсан).

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ✓ Хөтөлбөрийг хэлэлцсэн хурлын протокол
- ✓ Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан

Онцлог зүйл/Туршлага:

- ✓ Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 –г хэрэгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- ✓ Менежментийн багийн хурал, хөтөлбөрийн дэд хорооны хурал зэрэг холбогдох шат шатны хурлын мэдээллийг нэгтгэдэг.
- ✓ Өөрийн үнэлгээний тайланд дотоод мониторинг, үнэлгээний талаар илүү туссан. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт, сайжруулалтын талаар тусгах

Зөвлөмж:

- ✓ Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг PDCA зарчмаар хэрэгжүүлэх;
- ✓ Хөтөлбөр хүрэх үр дүндээ хүрч байгаа талаарх үнэлгээг хийж, сайжруулдаг тогтолцоог бүрдүүлэх;
- ✓ Оролцогч талуудыг судалгаанд бүрэн хамруулах, тэдний санал зөвлөмжийг хөтөлбөртөө сайн тусгадаг байх

Шаардлага: / хэсэгчлэн болон хангаагүй гэж дүгнэсэн үед бичнэ/

- ✓ Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалтыг тасралтгүй хийхийн тулд дараах асуудлуудад анхаарах шаардлагатай. Үүнд:
 - ✓ Тус хөтөлбөрийг тасралтгүй сайжруулахын тулд мэргэжлийн суурь хичээлийг зааж буй, бүрэлдэхүүн сургууль болон мэргэжлийн сургуулийн хамтын ажиллагааг сайжруулах зайлшгүй шаардлагатай.
 - ✓ Хөтөлбөрт томоохон хэмжээний өөрчлөлт хийх үед зөвхөн хөтөлбөр хариуцаж буй нэгж /баг/ бус ШУТИС-ийн олон бүрэлдэхүүн сургууль дамнасан байдлаар сайжруулалтыг хийгдэхээр байгаад анхаарах шаардлагатай.
 - ✓ Хөтөлбөр хариуцсан нэг багш /дэд профессор/-д ногдох ачаалал хэтэрхий их байгааг анхаарах шаардлагатай. (ӨҮТ-ийн 128 хуудас: 2018 онд Тээврийн менежмент мэргэжлийн өөрийн үнэлгээг хийсэн бөгөөд **тайланг хөтөлбөр хариуцсан дэд профессор** боловсруулан МехТС-ийн хөтөлбөрийн үнэлгээний комиссоор оруулан хэлэлцэж, зарим нэг асуудлыг сайжруулах зөвлөгөө авсан. Энэхүү зөвлөмжийн дагуу сургалтын төлөвлөгөөг засан сайжруулж, ахин батлуулахаар багийн, салбарын болон МехТС-ийн хөтөлбөрийн хорооны хурлаар хэлэлцээд, СБЗГ-т танилцуулахаар илгээсэн байгаа. (Шинжээчийн баг ажиллах үед энэ талаарх хариу байхгүй)).
 - ✓ Өөрийн үнэлгээний тайланг шинээр бичих шаардлагатай (өөрөөр хэлбэл, өмнөх тайлангуудын ихэнхи хэсгүүдтэй давхардсан, зөвхөн зарим тоон мэдээллийг л шинэчилсэн байдалтай бичигдэн байна)

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- ✓ Хурлын протокол
- ✓ Төгсөгчид, ажил олгогчдын мөшгих судалгаа /Хөтөлбөр хариуцсан багшийн хувийн мэдээлэл/

Анхаарах асуудал:

- ✓ Холбогдох хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл, хэлэлцсэн асуудлууд нь тодорхой байх, хурлын тэмдэглэлийг хариуцах нэгж тодорхой байхад анхаарах,
- ✓ Хөтөлбөрийг боловсруулахад хөтөлбөрийн хороон дахь ажил олгогч (тээврийн салбарын), төгсөгчдийн төлөөлөл тодорхойгүй байгаад анхаарах,

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ✓ 2010 онд магадлан итгэмжлэгдсэн /хугацаа дууссан/
- ✓ ШУТИС-ийн дараах хөтөлбөрүүд магадлан итгэмжлэгдсэн байна. /БМИУЗ-ийн мэдээлэл/
 - D041302 Менежмент /Жижиг дунд үйлдвэрлэлийн менежмент/
 - D041302 Менежмент /Харилцаа холбооны менежмент/
 - D041302 Менежмент /Хөнгөн үйлдвэрлэлийн менежмент/

Анхаарах асуудал:

- ✓ Цаашид өөрийн үнэлгээний тайлангийн боловсруулалтад анхаарах (Жишээ нь: ӨҮТ 140-р хуудас: ... багш нар докторын зэргээ амжилттай хамгаалаад одоо буцаад сургуульдаа ажиллаж байгаа нь манай хөтөлбөрийг олон улсад хүлээн зөвшөөрөгдөж байгаагийн нэг илрэл болж байна.)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

ШУТИС-ийн МехТС-ийн “Менежмент” хөтөлбөрт шинжээчдийн зүгээс дараах нэгдсэн үнэлгээг өгч байна.

| Шалгуур | | Бүрэн Хангасан (2) | Хэсэгчлэн хангасан (1) | Хангаагүй (0) | Үндэслэл, шалтгаан/хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт бичнэ/ |
|---------|--|--------------------|------------------------|---------------|---|
| 1. | Хөтөлбөрийн төлөвлөлт | 2 | 1 | - | Бүрэн хангасан |
| 2. | Сургалтын үйл ажиллагаа | 3 | - | - | Бүрэн хангасан |
| 3. | Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл | 2 | 1 | - | Бүрэн хангасан |
| 4. | Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт | 5 | - | - | Бүрэн хангасан |
| 5. | Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа | 5 | - | - | Бүрэн хангасан |

| | | | | | |
|------------------------|-------------------------------|-----------------------|---|---|----------------|
| 6. | Багшийн үйл ажиллагаа | 4 | - | - | Бүрэн хангасан |
| 7. | Чанарын үнэлгээ, баталгаажилт | 2 | 1 | - | Бүрэн хангасан |
| Нэгдсэн үнэлгээ | | БҮРЭН ХАНГАСАН | | | |

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургуулийн “Менежмент” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “**ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН**” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнесийн удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

| | |
|---------------------------------------|---|
| Сургуулийн нэр | ШУТИС, Механик, тээврийн сургууль |
| Хөтөлбөрийн нэр | Менежмент |
| Хөтөлбөрийн индекс | D041302 |
| Зөвлөмж | |
| Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт | <ul style="list-style-type: none"> ✓ Гадаад, дотоодын их сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан шинжилгээний үр дүнг хөтөлбөрт тусгадаг байх; ✓ Монгол улсын тээврийн салбарт ажиллагсдын судалгааг дэлгэрэнгүй хийж, хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг зөв тодорхойлж, хөтөлбөрөө сайжруулахад ажил олгогчид болон тухайн салбарын мэргэжилтнүүдийн оролцоог бүрэн хангаж ажиллах; ✓ Хөтөлбөрийн боловсролын зорилго нь тухайн хөтөлбөрөөр төгсөгч нь ажлын байранд гараад 4-5 жилийн дараах хэрэглэж чадах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байхаар тодорхойлж сайжруулах. ✓ Хөтөлбөрийн хичээл нэг бүрийн суралцахуйн үр дүнг (CLOs) хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүйн зөвлөмж бүхий гарын авлага боловсруулж, хөтөлбөрийн багш нарт хүртээл болгон ажиллах. |
| Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа | <ul style="list-style-type: none"> ✓ Хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг хийхдээ хөтөлбөрийн хүрэх үр дүн, төгсөгчийн загварт шинэчлэлт хийсний дараа сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт хийдэг байх; ✓ Хөтөлбөрийн онцлогоос хамааран ямар сургалтын аргууд тухайн хөтөлбөрт тохирох, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх арга зүй, удирдамж, заавар гаргаж ажиллах; ✓ Хөтөлбөрийн багш нэр өөрийн хичээл нэг бүрийн суралцахуйн үр дүнг (CLOs) хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүйн зөвлөмж гаргаж ажиллах; ✓ Багш нарыг сурган, заах арга зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, тасралтгүй хөгжүүлэх багшийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг гаргаж, хэрэгжүүлэх; ✓ Хичээлийн өөрийн үнэлгээний тайланг дүгнэж хэвших. |

| | |
|--|--|
| <p>Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц</p> | <ul style="list-style-type: none"> ✓ Төмөр зам, агаар, усан тээврийн лабораторийг бий болгох. ✓ Анги танхим, дотуур байрны дулаалга, халаалтын асуудлыг сайжруулахад анхаарах; ✓ Бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамжийг сайжруулахад анхаарах; ✓ Мэргэжлийн дадлага хийх хугацаа, кредит цагийг нэмэгдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх; ✓ Дадлага хийж буй оюутнуудын аюулгүй байдлыг хангахад анхаарч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгч байх; ✓ Мэргэжлийн чиглэлээрх албан ёсны лицензтэй программын тоог нэмэгдүүлэх; ✓ Номын сангийн фондыг тээврийн менежмент хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийн үндсэн сурах бичгээр баяжуулах ✓ Үндсэн сурах бичиг, ном, гарын авлагын талаар оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч түүний дагуу арга хэмжээ авч ажиллах; |
| <p>Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт</p> | <ul style="list-style-type: none"> ✓ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх; ✓ Хөтөлбөрийг сайжруулахад оролцогч талуудын (багш, оюутан) оролцоог хангаж ажиллах; ✓ Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах сэтгэл ханамжийн судалгааг хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл хөтлөх, хөтөлбөр сайжруулалтыг бодитоор хийх; ✓ Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг өргөжүүлж, энэхүү мэргэжлээр суралцаж буй оюутан залуустай төгсөгч-оюутнуудын хамтарсан уулзалт зохион байгуулж туршлага хуваалцаж байх; ✓ Тээвэр-логистикийн байгууллагууд болон тээвэр зуучийн байгууллагуудтай хамтран ажиллах урт, богино хугацааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх; ✓ Багш нарын гадаад дотоод эрдэм шинжилгээний хуралд оролцоход дэмжлэг өгч, урамшуулж байх; ✓ Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайланг гаргадаг байх; ✓ Багш нарт ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэх төсөв санхүүг нэмэгдүүлэх; |
| <p>Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ</p> | <ul style="list-style-type: none"> ✓ Багш нар өөрийн заасан хичээлийн сэтгэл ханамжийн судалгаатай танилцдаг байх, тухайн судалгааны үр дүнг хөтөлбөрийг хэрэгжүүлж буй баг хэлэлцдэг байх. |
| <p>Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа</p> | <ul style="list-style-type: none"> ✓ Тээврийн салбар (инженерийн ухаан) –ын нэг чиглэл болж 041302 Менежмент /тээврийн менежмент/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлуудыг сургуулийн холбогдох нэгжүүд шийдвэрлэх шаардлагатай. ✓ Багшийн сургалт, судалгааны үйл ажиллагаанд дэмжлэг тусламж үзүүлэх; |
| <p>Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт</p> | <ul style="list-style-type: none"> ✓ Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг PDCA зарчмаар хэрэгжүүлэх; ✓ Хөтөлбөр хүрэх үр дүндээ хүрч байгаа талаарх үнэлгээг хийж, сайжруулдаг тогтолцоог бүрдүүлэх; ✓ Оролцогч талуудыг судалгаанд бүрэн хамруулах, тэдний санал зөвлөмжийг хөтөлбөртөө сайн тусгадаг байх; |

| ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/ | |
|---|---|
| 1.3. Хөтөлбөрийн төлөвлөлт | <ul style="list-style-type: none"> ✓ Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгийг сайжруулахдаа дараах зүйлийг анхаарч ажиллах: Үүнд: <ul style="list-style-type: none"> ○ Хөтөлбөрийн боловсролын үр дүнг (PEOs)-ийг суралцахуйн үр дүнтэй нийцүүлэх; ○ Хөтөлбөрийн зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнг тодорхойлохдоо багш, ажил олгогч, төгсөгч зэрэг оролцогч талуудын оролцоог хангаж, хэлэлцүүлэн гаргадаг байх; ○ Хөтөлбөрийн эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох холбогдох нотлох баримтуудыг архивлан хөтөлж байх. Үүнд: оролцогч талуудын сэтгэл ханамжийн тайлан, судалгааны үр дүнг танилцуулсан уулзалт, хийсэн хэлэлцүүлэг, асуудлыг шийдвэрлэсэн байдал, хөтөлбөрийн эрэлт хэрэгцээний тандан судалгаа, STEEP, POEMS зэрэг шинжилгээг хийсэн ажлын хэсгийн тушаал, тайлан, гаргасан дүнг хөтөлбөрийн төлөвлөлтөд оруулсан тухай тушаал, албан тоот гэх мэт. ○ Багш бүрийн хичээлийн иж бүрдлийг лекцийн материалаас гадна дадлага хичээл болон түүнийг удирдан явуулах сургалтын арга зүйн удирдамж, лабораторийн заавар, явцын болон улирлын шалгалтын материал, бие даалтын удирдамж, бусад хэрэглэгдэхүүний талын мэдээллийг бүрэн оруулах, эдгээр бичиг баримтын төлөвлөлтийг үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу боловсруулах |
| 7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт | <ul style="list-style-type: none"> ✓ Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалтыг тасралтгүй хийхийн тулд дараах асуудлуудад анхаарах шаардлагатай. Үүнд: <ul style="list-style-type: none"> ✓ Тус хөтөлбөрийг тасралтгүй сайжруулахын тулд мэргэжлийн суурь хичээлийг зааж буй, бүрэлдэхүүн сургууль болон мэргэжлийн сургуулийн хамтын ажиллагааг сайжруулах зайлшгүй шаардлагатай. ✓ Хөтөлбөрт томоохон хэмжээний өөрчлөлт хийх үед зөвхөн хөтөлбөр хариуцаж буй нэгж /баг/ бус ШУТИС-ийн олон бүрэлдэхүүн сургууль дамнасан байдлаар сайжруулалты хийгдэхээр байгаад анхаарах шаардлагатай. ✓ Хөтөлбөр хариуцсан нэг багш /дэд профессор/-д ногдох ачаалал хэтэрхий их байгааг анхаарах шаардлагатай. (ӨҮТ-ийн 128 хуудас: 2018 онд Тээврийн менежмент мэргэжлийн өөрийн үнэлгээг хийсэн бөгөөд тайланг хөтөлбөр хариуцсан дэд профессор боловсруулан МехТС-ийн хөтөлбөрийн үнэлгээний комиссоор оруулан хэлэлцэж, зарим нэг асуудлыг сайжруулах зөвлөгөө авсан. Энэхүү зөвлөмжийн дагуу сургалтын төлөвлөгөө засан сайжруулж, ахин батлуулахаар багийн, салбарын болон МехТС-ийн хөтөлбөрийн хорооны хурлаар хэлэлцээд, СБЗГ-т танилцуулахаар илгээсэн байгаа. (Шинжээчийн баг ажиллах үед энэ талаарх хариу байхгүй)). ✓ Өөрийн үнэлгээний тайланг шинээр бичих шаардлагатай (өөрөөр хэлбэл, өмнөх тайлангуудын ихэнхи хэсгүүдтэй давхардсан, зөвхөн зарим тоон мэдээллийг л шинэчилсэн байдалтай бичигдэн байна) |

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Р.Чанцалдулам

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Б.Батдэлгэр

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Б.Буманцэцэг

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс:

I. Багш нарын нэрс

| № | Овог нэр | Албан тушаалын зэрэг | Заадаг хичээл | Ажилласан жил |
|----|---------------|----------------------------------|---|---------------|
| 1. | И.Базаррагчаа | Салбарын эрхлэгч | Автотээврийн хэрэгсэл Замын хөдөлгөөний аюулгүй байдал | 24 |
| 2. | С.Ариунбаяр | Хөтөлбөр хариуцсан дэд профессор | Логистик | 16 |
| 3. | Б.Асралт | Ахмад гэрээт | Хотын нийтийн тээвэр | 43 |
| 4. | Б.Батбаяр | Ахлах багш | Төмөр замын тээврийн менежмент Тээврийн эдийн засаг | 15 |
| 5. | М.Дэлгэрнасан | Ахлах багш | Авто тээврийн менежмент Агаарын тээврийн менежмент | 24 |
| 6. | Л.Чулуунцэцэг | Ахлах багш | Тээврийн нэгдсэн систем | 22 |
| 7. | С.Уянга | Ахлах багш | Агаарын тээврийн менежмент Олон улсын стандарт эрхзүй Олон улсын тээврийн зуучлалын менежмент | 6 |
| 8. | Г.Ариунбямбаа | Ахлах багш | Харилцааны англи хэл Бизнес менежментийн англи хэл Тусгай зориулалтын англи хэл | 18 |
| 9. | Д.Содномзул | Ахлах багш | Микро эдийн засаг Макро эдийн засаг | 14 |

II. Оюутны нэрс

Тээврийн менежмент

| № | Оюутны овог, нэр | Анги | Сонгосон байдал |
|-----|------------------|----------|-------------------------------|
| 1. | Б.Мөнхнасан | 3-р курс | Дотуур байранд |
| 2. | О.Алтаншагай | 3-р курс | Орон нутгийн |
| 3. | Б.Энэбиш | 3-р курс | Орон нутгийн |
| 4. | Г.Удвал | 3-р курс | Шилжиж ирсэн |
| 5. | Т.Анужин | 3-р курс | Хотынх |
| 6. | О.Баттүшиг | 3-р курс | Холоос хичээлдээ явдаг |
| 7. | Д.Уранчимэг | 3-р курс | Дотуур байранд өмнө нь байсан |
| 8. | Т.Баясгалан | 4-р курс | Хотынх |
| 9. | Т.Хүрэлбаатар | 4-р курс | Холоос хичээлдээ явдаг |
| 10. | П.Даваажаргал | 4-р курс | Орон нутгийн |
| 11. | А.Батзолбоо | 4-р курс | Орон нутгийн |
| 12. | Т.Ганзул | 4-р курс | Хотынх |
| 13. | Д.Ариунтунгалаг | 4-р курс | Хотынх |
| 14. | Н.Баяраа | 4-р курс | Орон нутгийн |
| 15. | Б.Нацагдорж | 4-р курс | Орон нутгийн |
| 16. | М.Золжаргал | 4-р курс | Хотынх |
| 17. | Н.Сундуйбазар | 4-р курс | Дотуур байранд өмнө нь байсан |
| 18. | Б.Буянтогтох | 4-р курс | Холоос хичээлдээ явдаг |

III. Ажил олгогчдын нэрс

| № | Овог нэр | Байгууллага | Албан тушаал |
|-----|----------------|------------------------|----------------------------|
| 1. | Ё.Жаргалсайхан | ЗТХЯам | АТБХЗГ Дарга |
| 2. | Сонинбаатар | Зорчигч тээвэр 3 ХК | Хэлтсийн дарга |
| 3. | Уранцэцэг | Landbridge ХХК | Хүний нөөцийн менежер |
| 4. | Давааням | Monex ХХК | Дэд захирал |
| 5. | Х.Булгаа | Нийтийн тээврийн газар | Орлогч дарга |
| 6. | Минжигмаа | Туушин ХК | ТЗХН Дарга |
| 7. | Оюунчимэг | УБТЗ ХНН | Хүний нөөцийн газрын дарга |
| 8. | Г.Пүрэвдулам | ИНЕГ | Хүний нөөцийн газрын дарга |
| 9. | Гантуул | Эрдэнэс ТТТөмөр зам | ХНөөцийн мэргэжилтэн |
| 10. | Бат-Очир | Ачир ХХК | Тээврийн менежер |
| 11. | Буд-Эрдэнэ | Jurmak ХХК | Ерөнхий менежер |
| 12. | Г.Энхнаран | Mon logistics ХХК | Маркетингийн менежер |
| 13. | Амгалантөр | Тэнүүн огоо ХХК | Ерөнхий инженер |
| 14. | Бат-Оргил | Прайд Транс ХХК | Тээврийн зохицуулагч |
| 15. | Оюундарь | United Shipping LLC | Тээврийн менежер |

IV. Төгсөгчдийн нэрс

| № | Төгсөгчийн овог нэр | Төгссөн он | Байгууллага, албан тушаал |
|-----|---------------------|------------|---|
| 1. | М.Хулан | 2017 | Ландбридж ХХК, логистик менежер |
| 2. | М.Батдөлгөөн | 2017 | Ландбридж ХХК, талбайн пүүлэгч |
| 3. | С.Сайнаа | 2017 | Inter Reliance Logistics LLC, логистикийн мэргэжилтэн |
| 4. | Б.Бурмаа | 2017 | Монложистик Транзит ХХК, мэргэжилтэн |
| 5. | Ц.Мөнхцэцэг | 2017 | United Shipping ХХК, мэргэжилтэн |
| 6. | П.Должинсүрэн | 2017 | “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, мэргэжилтэн |
| 7. | Ө.Серкбол | 2018 | Налайхын уурхай, менежер |
| 8. | Б.Цэнгүүн | 2018 | Ти Ай Ложистик ХХК, Гаалийн мэргэжилтэн |
| 9. | Э.Адъяабаатар | 2019 | Тера Экспресс ХХК, Тээвэр зохицуулагч |
| 10. | Б.Пүрэвтогтох | 2019 | Тера Экспресс ХХК, Тээвэр зохицуулагч |
| 11. | Э.Пүрэвсүрэн | 2019 | Хишиг Сайхан Ундрах ХХК, тээврийн менежер |
| 12. | Д.Алтансүх | 2020 | ГХЯам, Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар, нярав /Автобааз/ |
| 13. | Э.Юмдүүжин | 2019 | Хүннү Эйр ХХК, мэргэжилтэн |
| 14. | Т.Учрал | 2020 | Японд их сургуульд сурахаар хүлээж байгаа |
| 15. | О.Золбаяр | 2020 | Централ бласт ХХК, түгээлтийн мэргэжилтэн |
| 16. | Г.Маналжав | 2020 | UMT Vega ХХК, захирал |
| 17. | С.Чулуунбат | 2021 | Ulaanbaatar airport shuttle компани, үйл ажиллагааны менежер |
| 18. | Л.Содном | 2021 | МБ Транс ХХК, менежер |
| 19. | Д.Төрболд | 2021 | Энгүй ундарга ХХК, бараа материал хүлээн авагч |
| 20. | О.Ганчимэг | 2021 | Нийслэлийн Замын Хөдөлгөөн Төлөвлөлт Зохицуулалт Инженерчлэлийн газар, тээвэр логистикийн инженер |

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
МЕХАНИК, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ

17033 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо,
Чингисийн өргөн чөлөө, Энгельсийн гудамж,
Утас/Факс: (976-11) 34 19 13,
И-мэйл: dtsolmon@must.edu.mn, Вэбсайт: must.edu.mn

2022.01.10 № 115

танай _____-ны № _____-т

Хүсэлт гаргах тухай

Тус сургуулийн "Менежмент" хөтөлбөрийн "Тээврийн менежмент" мэргэжилд магадлан итгэмжлэл хийж байгаа хөндлөнгийн үнэлгээний багийн Шинжээчийн тайланг хүлээж авлаа. Бидний зүгээс та бүхний ирүүлсэн илрэл нотолгоо, онцлог зүйл, туршлага, зөвлөмж, анхаарах асуудал, шаардлага зэрэгтэй бүрэн санал нийлж байна.

"Тээврийн менежмент" мэргэжил нь ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд дээр хэрэгжүүлж байгаа "Менежмент" хөтөлбөрт багтах нэг мэргэжил юм. Тус мэргэжлийн хөтөлбөр нь 2014 онд ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлөөр батлагдсан баримт бичиг бөгөөд одоогоор хөтөлбөрийн шинэчлэлт хийгдэж байгаа боловч албан ёсоор батлагдаагүй байна.

Харин хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг "Менежмент" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн сүүлийн таван жилийн үйл ажиллагааг нэгтгэн 2021 онд боловсруулсан. Ялгаатай цаг хугацаанд батлагдсан хөтөлбөр болон бичигдсэн тайлангийн хооронд зарим зөрүү үүссэн байх магадлалтай. Иймээс шаардлага хэсэгт бичигдсэн асуудлуудыг анхаарах асуудал хэсэгт оруулах саналыг шинжээчийн багт хүргүүлж байна.

Мөн тайлангийн дүгнэлт хэсэгт тус мэргэжлийг хэрхэн үнэлж байгааг тодорхой тусгаж өгнө үү.

ЗАХИРАЛ



Д.ЦОЛМОНБААТАР

267789007

/албан бичгийг оруулах/

I. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

| Магадлан итгэмжлэх эсэх | Магадлан итгэмжлэл олгох хугацаа |
|-------------------------|----------------------------------|
| | |

Зөвлөмж /Recommendations/

YII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх

Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/